


БАТЛАВ.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Б.ПҮРЭВДОРЖ

2025.09.10

**УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДЭГЧДИЙГ ЦАГААТГАХ, ТЭДЭНД
НӨХӨХ ОЛГОВОР ОЛГОХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хууль /цаашид Хууль гэх/ 1998 онд батлагдаж Монгол Улсын нутаг дэвсгэрт улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгаж нэр төрийг нь сэргээх, тэдэнд нөхөх олговор олгох, улс төрийн хэлмэгдүүлэлтийн бусад үр дагаврыг арилгахтай холбогдсон харилцааг зохицуулж байна.

Энэ хугацаанд хуулийн 4 дүгээр зүйлд заасан үйлчлэх хүрээнд хамаарах ...хүний хэргийг цагаатгаж, нэр төрийг нь сэргээн 31661 хүний хэргийг цагаатгаж, нэр төрийг нь сэргээн 931 хүнд 43 тэрбум 780 мянган төгрөгийн нөхөн олговор олгох шийдвэр гарчээ. Уг хуулийн Гуравдугаар бүлгээр зохицуулсаны дагуу Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгч мөн болох нь хууль ёсоор тооцогдсон этгээдэд учирсан хохиролыг

- улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгч өөрөө;
- хэлмэгдэгч нас барсан бол түүний эхнэр буюу нөхөр нь түүнийг нас барснаас хойш өөр хүнтэй гэрлэсэн эсэхээс үл хамааран;
- хэлмэгдэгчийг амьд байхад нь төрсөн болон үрчилж авсан, түүнчлэн хэлмэгдэгчийг нас барснаас нь хойш 10 сараас илүүгүй хугацааны дотор төрсөн хүүхэд;
- эдгээр байхгүй бол хэлмэгдэгчийн төрсөн эцэг, эх, ах, эгч, дүү, ач, зээ нэхэмжилсэнийг үндэслэн хэлмэгдэгчийг цагаатгасан тухай эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн нэхэмжлэгчийн оршин суугаа нутаг дэвсгэрийг харьяалах анхан шатны шүүхэд гаргахаар зохицуулсан.

Харин “Нэхэмжлэл гаргах эрх нь энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс өмнө цагаатгагдсан иргэдийн хувьд 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор, энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш цагаатгагдсан иргэдийн хувьд цагаатгасан шийдвэрийг хүлээн авснаас хойш 3 жилийн хугацаанд байна” хэмээн мөн хуулийн 12 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан.

Харин хуулийн 13.1 дүгээр зүйлд хамаарах улс төрийн хилс хэрэгт холбогдуулан цаазаар авах ял шийтгүүлсэн хэлмэгдэгчийн гэр бүлийн гишүүдэд болон хорих ялаар шийтгүүлсэн хэлмэгдэгчид, хэрэв хэлмэгдэгч нас барсан бол түүний гэр бүлийн гишүүн 25 хүн, 13.2 дугаар зүйлд хамаарах хэлмэгдэгчийн төрсөн болон үрчилж авсан хүүхэд 44 хүн одоогийн байдлаар “Ковидын үе таарч мэдээллээс хоцорсон, хэлмэгдэгчийн овог нэрийг тодорхойлж чадаагүй удсан, цагаатгасан талаар өөрт нь мэдэгдээгүй, хожим өөр эх сурвалжаас олж мэдсэн гэх зэрэг янз бүрийн шалтгаанаар хуулийн дагуу нэхэмжлэл гаргаж нөхөн олговор авч чадалгүй хоцорчээ.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өнөөг хүртэл нийт 13 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан байх бөгөөд эдгээр нэмэлт, өөрчлөлтийн 5 буюу 2000, 2002, 2006, 2009, 2018 онуудад оруулсан нэмэлт өөрчлөлтөөр дурдан нэхэмжлэл гаргах хугацааг зохицуулсан 12.3 дугаар зүйлд нэмэлт өөрчлөлт оруулж байжээ. Ийнхүү нэмэлт өөрчлөлт оруулах болсон нь өнөөдөр үүсээд буй нэхэмжлэл гаргаж чадаагүй иргэдийн эрхийг хангах гэсэн нэгэн ижил нөхцөл, шалтгаантай байна.

Хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийж үзэхэд мөн Хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “7.2.Улс төрийн хилс хэрэгт холбогдуулан захиргааны шийдвэрээр нутаг заагдсан, ажил, албан тушаалаасаа халагдсан хүмүүст холбогдох гомдлыг анхан шатны шүүх иргэний Эрхийг хохироосон төрийн захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус үйл ажиллагааны талаар шүүхэд гомдол гаргах журмын тухай Монгол Улсын хуульд заасны дагуу хянан шийдвэрлэнэ” гэж заасан боловч дурдан буй Эрхийг хохироосон төрийн захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус үйл ажиллагааны талаар шүүхэд гомдол гаргах журмын тухай Монгол Улсын хуулийг 2002 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар хучингүй болсонд тооцсон. Өөрөөр хэлбэл, Хуулиар нэгэнт хүчингүй болсон хуулиар тогтоосон журмаар гомдол гаргах тухай зохицуулалт үлдээж эрх зүйн хийдэл үүсгэжээ.

Хуулийн 6.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “6.3.Цагаатгуулах тухай гомдлыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор гаргаж болох бөгөөд энэ хугацаанаас хойш гаргасан гомдлыг хүлээж авахгүй” гэснийг хуулийн хэрэгжилтэд тулгамдсан практик шаардлагад нийцүүлэн 2000 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн хууль, 2006 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хууль, 2009 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн хууль 2018 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулж эцэст нь 2024 оны 05 сарын 16-ны өдрийн хуулиар хүчингүй болгосон байна. Гэсэн атлаа уг гомдол гаргах эрхийн үргэлжлэл болсон нэхэмжлэл гаргах эрхийг 12 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт уламжлалт байдлаар хугацаа тогтоон орхисон нь өдгөө 50 гаруй иргэний хилс хэрэгт шийтгүүлэн хэлмэгдсэн эрхээ сэргээлгэж нөхөн олговор авах эрхийг хязгаарласан зохицуулалт болон үлдсэн байна.

Түүнчлэн Хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийж үзэхэд Хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-д хүчингүй болсон хуулийг дурдан иргэний гомдлыг шийдвэрлэхээр заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “хууль дээдлэх” төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг зөрчсөн; Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсэдийн эрхийг нөхөн сэргээхийн тулд төрөөс хүний эрхэнд халдан хязгаарласан үйл ажиллагааныхаа хариуцлагыг бүрэн хүлээж хувь хүнд байхгүй, байх боломжгүй нотлох баримтыг иргэнээс шаардаж Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 12 дахь хэсэгт заасан “төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй”, 14 дэх хэсэгт заасан “нотлох баримтыг шалгуулах”, 17 дахь хэсэгт заасан “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах” эрхийг тус тус зөрчсөн нөхцөл байдал тогтоогдов.

Иймд Хуулийн зорилтыг хангаж улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсэдэд нөхөн олговор олгох ажлыг бүрэн хэрэгжүүлэхийн энэ Хуульд зохих нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Хоёр.Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа

Хуулийн төсөлд Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэгт өөрчлөлт оруулж нөхөн олговороос хоцорсон иргэдийн нэхэмжлэл гаргах хууль зүйн боломжийг нээнэ.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар Хуулийн зорилт хангагдаж нөхөн олговороос хоцорсон иргэдийн нэхэмжлэл гаргах эрх нээгдэнэ.

Энэхүү төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургаадугаар зүйлийн 12, 14, 17 дахь хэсэгт заасан эрхүүдийг хангаж байгаа нь тус хуулийн нийгэм, хууль зүйн үр дагавар болно.

Нэмэлт өөрчлөлт оруулсанаар шүүхээс тогтоосон хэмжээнд Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчид нөхөн олговор олгох бөгөөд холбогдон гарах зардлыг урьдчилан тооцох боломжгүй.

Хуульд нэмэлт өөрчлөлт оруулсантай холбогдуулан бусад хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулахгүй.